

## **GS1 СИСТЕМ, ЗУРААСАН КОД ОЛГОХ, “GS1 MONGOLIA” НИЙГЭМЛЭГИЙН ХЭРЭГЛЭГЧ ГИШҮҮНЭЭР БҮРТГЭХ ЖУРАМ**

### **Нэг: Нийтлэг үндэслэл**

- 1.1 “GS1 Mongolia” нийгэмлэгээс бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд GS1 систем, зураасан код олгож хэрэглэгч гишүүнээр бүртгэх, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2 Бараа бүтээгдэхүүнд зураасан код олгох ажиллагааг Олон Улсын GS1 байгууллагаас олгосон эрх, гэрээний дагуу “GS1 Mongolia” нийгэмлэг гүйцэтгэнэ.

### **Хоёр: “GS1 Mongolia” нийгэмлэгт хэрэглэгч гишүүнээр бүртгэх**

- 2.1 “Гишүүн” гэж энэхүү журмын дагуу зураасан код авч хэрэглэгч гишүүнээр бүртгэгдсэн хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. (Салбар бүхий компанийн хувьд салбар бүр нь тусдаа гишүүнээр элсэж бүртгүүлнэ)
- 2.2 Монгол улсад тус системийг дэмжин сурталчлах, хэрэглэх сонирхол бүхий бүх хувь хүн, хуулийн этгээдэд хэрэглэгч гишүүнээр бүртгүүлэх, бүртгэх нь нээлттэй байна.
- 2.3 Нийгэмлэгийн хэрэглэгч гишүүнээр бүртгүүлж бараа бүтээгдэхүүн, үйлчилгээндээ зураасан код авахаар хүсэлт гаргагч бүх хувь хүн, хуулийн этгээд энэ журмын **Хавсралт №1**-д заасан маягтын дагуу “GS1 Mongolia” нийгэмлэгт өөрийнхөө болон бараа үйлчилгээнийхээ талаарх мэдээллийг үнэн зөв, гаргацтай бөглөж өгөх ба мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл гаргагч өөрөө хариуцна.
- 2.4 Хэрэглэгч гишүүнээр бүртгүүлэх хүсэлтэнд дор дурдсан баримт бичгийг хавсаргана.  
**А. Байгууллагын танилцуулга,**  
**Б. Аж ахуй нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /хувь хүн бол иргэний үнэмлэх, ажлын байрны дүгнэлт, тухайн бүтээгдэхүүний шинжилгээний бичиг/,**  
**В. Зураасан код хариуцсан ажилтан (итгэмжлэгдсэн төлөөлөгч) томилсон тухай албан бичиг,**  
**Г. GS1 систем, зураасан код олгох, “GS1 Mongolia” нийгэмлэгийн хэрэглэгч гишүүнээр бүртгэх журам”-тай танилцсан тухай албан бичиг,**  
**Д. Элсэлтийн хураамж төлсөн баримт.**
- 2.5 Энэхүү журмын 2.4-т заасан бичиг баримтыг бүрдүүлээгүй буюу дутуу бүрдүүлсэн тохиолдолд хүсэлтийг хүлээн авахгүй.
- 2.6 Системийн хэрэглэгч болохоор хүсэлт гаргаж буй хувь хүн, хуулийн этгээд **Хавсралт №2**-д заасны дагуу элсэлтийн хураамж төлнө.
- 2.7 Элсэлтийн хураамж төлж системийн хэрэглэгч болсон хувь хүн, хуулийн этгээд нь GS1 системийн талаарх шинэ соргог мэдээлэл, танилцуулга, ном хэвлэлтийг үнэгүй ашиглах эрхтэй.
- 2.8 Системийн хэрэглэгчид нь “GS1 Mongolia” нийгэмлэгийн бүх дүрэм журам, стандарт зохицуулалтыг дагаж мөрдөнө.
- 2.9 Системийн хэрэглэгч болсон хувь хүн, хуулийн этгээд нь жил бүр гишүүний татвар төлнө. Гэхдээ хэрэглэгч гишүүнээр бүртгүүлсэн эхний жилдээ татвар төлөхгүй.

- 2.10 Хэрэглэгч гишүүний татвар, хураамжийн хэмжээг “GS1 Mongolia” нийгэмлэгийн Удирдах зөвлөл тогтоох ба шаардлагатай үед нэмэлт өөрчлөлт оруулж болно. Хэрэглэгч гишүүний татварыг **Хавсралт №3**-д заасны дагуу төлнө.
- 2.11 Хэрэглэгч гишүүний эрх нь зөвхөн түүнд хамаарах ба өөрийн санаачлагаар бусдад үл шилжүүлнэ.

**Гурав: Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд GS1 систем, зураасан код олгох**

- 3.1 Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд зураасан код авахыг хүссэн хувь хүн, хуулийн этгээд нь зураасан код авах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр гарган **Хавсралт №4**-т заасан маягтын дагуу бөглөсөн өргөдлийг “GS1 Mongolia” нийгэмлэгт гаргана. Өргөдлийг үнэн зөв, гаргацтай бөглөх ба өргөдөлд дурдсан мэдээллийн үнэн зөвийг өргөдөлд гаргагч өөрөө хариуцна.
- 3.2 GS1 систем, зураасан кодыг зөвхөн компаниас итгэмжлэгдэн томилогдсон төлөөлөгчөөр дамжуулан бичгээр гаргасан хүсэлтийн үндсэн дээр олгоно.
- 3.3 “GS1 Mongolia” нийгэмлэг нь зураасан код авах тухай хүсэлт, энэ зүйлийн 3.2-т заасан холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 1-2 хоногт багтаан зураасан код олгоно.
- 3.4 Зураасан кодыг олон улсын жишгийн дагуу зориулалтаар хэрэглэх ба бусдад шилжүүлэх, худалдахыг хориглоно.

**Дөрөв: Хэрэглэгч гишүүний бүртгэлээс хасах, зураасан кодыг хүчингүй болгох**

- 4.1 Хэрэглэгч гишүүн нас барсан буюу албан ёсоор татан буугдсан тохиолдолд түүний нэрийг хэрэглэгчийн гишүүний бүртгэлээс хасна.
- 4.2 Хэрэглэгч гишүүн тухайн жилийнхээ төлөөгүй татвар, хураамжаа төлж барагдуулсан тохиолдолд нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэний үндсэн дээр хэрэглэгчийн гишүүний бүртгэлээс сайн дураараа гарч болно. Гэвч ийнхүү гарахдаа аль ч хугацаанд төлсөн татвар, хураамж эсвэл төлбөрөө буцаан авах эрхгүй байна.
- 4.3 Хэрэглэгч гишүүний татвар, хураамжаа нэг жил төлөөгүй гишүүний эрхийг цуцалж, нэрийг нь бүртгэлээс хасна. Гэвч үүнийг үл харгалзан түүний нэрийг хасах үед төлөөгүй байсан татвар, хураамжийг хүүгийн хамт төлөх үүрэгтэй хэвээр байна.
- 4.4 Хэрэглэгч гишүүн энэ журмын 2.11, 3.4 дугаар зүйлийг зөрчсөн нь батлагдвал уг кодыг хүчингүй болгож хэрэглэгч гишүүний эрхийг 3 жилийн хугацаатайгаар хасна.

**Тав: Бусад зүйл**

- 5.1 Зураасан код олгохтой холбогдсон гомдлыг “GS1 Mongolia” нийгэмлэгийн удирдлагад гаргана. Түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх эрхтэй.
- 5.2 Зураасан кодыг зориулалтын дагуу хэрэглээгүй, бусдад шилжүүлсэн, худалдсан, зураасан код олгох үйл ажиллагаанд саад учруулсан этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

oooo00000oooo

